

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛС, БҮГД НАЙРАМ-  
ДАХ ХЯТАД АРД УЛСЫН ХООРОНД ИРГЭНИЙ БОЛОН  
ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА  
ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс /цаашид "Хэлэлцэн тохирогч хоёр Тал" гэнэ/ төрийн бүрэн эрхт байдлыг харилцан хүндэтгэх, эрх тэгш, харилцан ашигтай байх үндсэн дээр тус хоёр орны эрх зүйн салбарын найрсаг хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэхийн тулд энэхүү Гэрээг байгуулахаар шийдвэрлэв.

Энэ зорилгоор Хэлэлцэн тохирогч хоёр Тал дор дурдсан зүйлийг тохиролцов.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

I дүгээр зүйл. Эрх зүйн  
хамгаалалт

I. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байхдаа Хэлэлцэн тохирогч тухайн Талын иргэдийн нэгэн адил эрх зүйн хамгаалалтад байна.

Энэ зорилгоор Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэдийн нэгэн адил нөхцөлөөр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын шүүхэд нэхэмжлэл гаргах буюу эрх бүхий бусад байгууллагад хүсэлт гаргаж болно.

2. Энэ зүйлийн I-ийн заалт нь Хэлэлцэн тохирогч хоёр Талын хуулийн этгээдэд нэгэн адил хамаарна.

2 дугаар зүйл. Эрх зүйн туслалцаа  
үзүүлэх

I. Хэлэлцэн тохирогч хоёр Талын эрх бүхий байгууллага энэ-

2.

хүү Гэрээнд заасны дагуу иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцааг харилцан үзүүлнэ.

2. Энэхүү Гэрээнд заасан "эрх бүхий байгууллага" гэж шүүх, прокурор, иргэний болон эрүүгийн хэрэг эрхлэх бусад байгууллагыг хэлнэ.

### 3 дугаар зүйл. Харилцах журам

1. Энэхүү Гэрээнд өөрөөр заагаагүй бол Хэлэлцэн тохирогч хоёр Талын эрх бүхий байгууллага бие биедээ хүсэлт тавих буюу эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхдээ өөрийн зохих төв байгууллагаар дамжуулан харилцаж байна.

2. Энэ зүйлийн 1-д заасан "төв байгууллага" гэж ҮНМАУ-ын хувьд ҮНМАУ-ын Хууль зүй, арбитрын Яам, ҮНМАУ-ын Дээд шүүхийг; БНХАУ-ын хувьд БНХАУ-ын Шүүх Яам, БНХАУ-ын Ардын дээд шүүхийг тус тус хэлнэ.

### 4 дүгээр зүйл. Даалгаврын агуулга, хэлбэр

1. Эрх зүйн туслалцаа үзүүлэхийг хүссэн даалгаврыг бичгээр гаргана. Даалгаварт:

а/ даалгавар өгсөн байгууллага, даалгавар хүлээн авах байгууллагын нэр, хаяг;

б/ хэргийн нэр;

в/ даалгавар биелүүлэхэд холбогдох хүмүүсийн овог, нэр,

3.

хүйс, иргэний харьяалал, төрсөн газар, он, сар, өдөр, эрхэлдэг ажил, байнга буюу түр оршин суугаа газар, байцаан шийтгэх ажиллагаанд оролцох эрхийн байдал, харин хуулийн этгээдийн хувьд нэр, хаяг;

г/ шаардлагатай бол зохигчдын төлөөлөгчдийн овог, нэр, хаяг;

д/ даалгавартай холбогдсон хэргийн товч агуулга; хэрэв эрүүгийн хэргийн талаар даалгавар өгвөл тухайн даалгавартай холбогдсон хэргийн нэр, гэмт хэргийн бодит байдал;

е/ даалгаврыг биелүүлэхэд шаардагдах хавсралт бусад баримт сэлт;

ж/ даалгаврын агуулгыг тусгасан байвал зохино.

2. Даалгаварт даалгавар өгсөн байгууллага гарын үсэг зурж, тэмдэг дарсан байна.

5 дугаар зүйл. Эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон зардал

1. Хэлэлцэн тохирогч хоёр Тал эрх зүйн туслалцааг харилцан үнэ төлбөргүй үзүүлнэ.

2. Даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт дуудагдсан гэрч буюу шинжээчийн замын болон байр, хоолны зардлыг даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Тал хариуцна. Түүнээс гадна шинжээч нь шинжилгээ хийсний шагнал авах эрхтэй.

Дуудагдаж байгаа этгээд ямар зардал авах эрхтэйг зарлан



дуудах хуудаст тодорхой заасан байна.

Дуудлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын байгууллага уг этгээдийн шаардсанаар зардлын урьдчилгаа олгоно.

6 дугаар зүйл. Гэрч, шинжээчийг хамгаалах

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын эрх бүхий байгууллагын дуудлагаар ирсэн гэрч, шинжээчийг аль улсын харьяат болохыг үл харгалзан, нутаг дэвсгэрт нь орохоос өмнө үйлдсэн гэмт хэрэг буюу гаргасан мэдүүлэг, дүгнэлттэй нь холбогдуулан эрүүгийн хариуцлагад татах буюу мөрдөх, баривчлах, хорих болон албадлагын бусад арга хэмжээ авч болохгүй.

2. Гэрч, шинжээч нь цаашид байх шаардлагагүй гэж мэдэгдсэнээс хойш даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс бололцоо байсаар атал 15 өдрийн дотор гарч яваагүй бол энэ зүйлийн I-д заасан баталгаа хүчингүй болно. Даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс гэрч, шинжээч өөрөөс нь үл шалтгаалах нөхцөл байдлын улмаас гарч чадаагүй саатсан хугацааг дээрх хугацаанд оруулан тоолохгүй.

3. Гэрч, шинжээчийг ирүүлэхийн тулд албадаж, сүрдүүлж болохгүй.

7 дугаар зүйл. Баримт бичгийн хүчин төгөлдөр байдал

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын эрх бүхий байгууллагаас өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу үйлдсэн буюу гэрчилсэн баримт бичгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт өөр ямар нэгэн баталгаагүйгээр хэрэглэж болно.

2.Хэлэлцэн тохирогч нэг Талын эрх бүхий байгууллагын үйлдсэн албан ёсны баримт бичиг нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт энэ Талын эрх бүхий байгууллагаас үйлдсэн адилтгах баримт бичгийн нэг адил хүчин төгөлдөр байна.

#### 8 дугаар зүйл.Харилцах хэл

I.Эрх зүйн туслалцаа үзүүлэх талаар өгөх даалгавар болон түүний хавсралт баримт бичгийг даалгавар өгч буй Хэлэлцэн тохирогч Талын хэлээр үйлдэж, түүнд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хэлний албан ёсны баталгаатай орчуулгыг, эсвэл англи хэлний орчуулгыг хавсаргасан байна.

2.Хэлэлцэн тохирогч нэг Талын эрх бүхий байгууллага Хэлэлцэн тохирогч нөгөө Талд эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ өөрийн улсын хэлийг хэрэглэнэ.

3.Хэлэлцэн тохирогч хоёр Талын төв байгууллага харилцахдаа англи хэлийг хэрэглэнэ.Түүнчлэн Хэлэлцэн тохирогч хоёр Тал монгол, хятад, англи хэлээр үйлдсэн хэвлэмэл хуудас хэрэглэж болох бөгөөд түүний загварыг харилцан солилцоно.

#### 9 дүгээр зүйл.Эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах

Хэрэв даалгавар хүлээж авсан Хэлэлцэн тохирогч Тал эрх зүйн туслалцаа үзүүлэх нь өөрийн орны бүрэн эрхт болон аюулгүй байдал, нийгмийн хэв журамд хохирол учруулахаар байна гэж үзвэл эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно.Гэхдээ татгалзсан шалтгааныг даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талд мэдэгдэнэ.

10 дугаар зүйл. Эрх зүйн туслалцаа  
үзүүлэхэд хэрэглэх хууль тогтоомж

Даалгавар хүлээн авсан байгууллага түүнийг биелүүлэхдээ өөрийн улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ. Даалгавар хүлээн авсан байгууллага өөрийн улсын хууль тогтоомжид харшлахгүй бол даалгавар өгсөн байгууллагын хүсэлтээр тэрхүү улсын байцаан шийтгэх ажиллагааны хэм хэмжээг хэрэглэж болно.

#### ХОЁРДУГААР ХЭСЭГ

ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ  
ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ

#### II дүгээр зүйл. Тодорхойлолт

Энэхүү Гэрээнд заасан "иргэний хэргийн эрх зүйн туслалцаа" гэдэгт аж ахуй, гэр бүлийн болон хөдөлмөрийн зэрэг хүрээнд дэх эрх зүйн туслалцаа хамаарна.

12 дугаар зүйл. Шүүхийн зардлаас  
хөнгөлөх, чөлөөлөх

Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт шүүхийн ажиллагаанд оролцож байгаа Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн тэр Талын нутаг дэвсгэрт хэрэг хянан хэлэлцэхтэй холбогдон гарах шүүхийн зардлыг тухайн Талын иргэний нэг адил нөхцөл, хэмжээгээр хэсэгчлэн буюу бүрэн чөлөөлүүлэх асуудлыг түүнээс гаргасан өргөдлийг үндэслэн уг өргөдлийг хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын шүүх өөрийн улсын хууль тогтоомжийг баримтлан шийдвэрлэж байна.



7.

13 дугаар зүйл. Баримт бичгийг хүргүүлэх болон шалгаж нотлох

Хэлэлцэн тохирогч Тал бүр нөгөө Талын хүсэлтээр эрх зүйн болон эрх зүйн бус баримт бичгийг хүргүүлэх, гардуулан өгөх, уг баримт бичгийн талаар зохигчид, гэрч, шинжээчээс асууж тодруулах, үзлэг, шинжилгээ хийх буюу шалгаж нотлохтой холбогдсон байцаан шийтгэх бусад ажиллагаа явуулна.

14 дүгээр зүйл. Даалгавар биелүүлэх

1. Хэрэв даалгавар хүлээн авсан байгууллага түүнийг биелүүлэх эрхгүй бол уг даалгаврыг биелүүлэх эрх бүхий байгууллагад шилжүүлснээ даалгавар өгсөн байгууллагад мэдэгдэнэ.

2. Даалгавар хүлээн авсан байгууллага уг даалгаварт дурдсан хаягаар түүнийг биелүүлэх аргагүй бол өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу хаягийг тогтоох арга хэмжээ авна. Шаардлагатай бол даалгавар өгсөн байгууллагаас нэмэлт тодотгол хийж өгөхийг хүсч болно.

3. Хэрэв хаяг тогтоох аргагүй буюу бусад шалтгаанаар даалгаврыг биелүүлж чадахгүй бол даалгавар хүлээн авсан байгууллага түүнийг өгсөн байгууллагад мэдэгдэж, даалгавар биелүүлэхэд саад болж байгаа шалтгааныг тайлбарлан даалгавар болон хавсралт бүх баримт бичгийг буцаана.

15 дугаар зүйл. Биелэлтийг мэдэгдэх

1. Даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч нөгөө Талд даалгаврын биелэлтийг мэдэгдэж, харду нотолгоо болон хүлээж авсан баримт сэлтийг хавсарган хүргүүлнэ.

2. Хүргүүлэх хариу нотолгоонд хүргүүлж байгаа байгууллагын тэмдэг дарах, хүргүүлэгчийн болон хүлээн авагчийн гарын үсэг зурах, мөн хүргүүлэх хэлбэр, он, сар, өдөр, газрыг заах ёстой. Хэрэв хүлээн авагч хариу нотолгоог хүлээн авахаас татгалзвал шалтгаанаа тодорхой тэмцэглэх ёстой.

16 дугаар зүйл. Дипломат төлөөлөгчийн буюу консулын газрын эрх мэдэл

1. Хэлэлцэн тохирогч нэг Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талд суугаа дипломат төлөөлөгчийн буюу консулын газраараа дамжуулж нөгөө Талын нутаг дэвсгэрт суугаа өөрийн улсын иргэдэд баримт бичиг хүргүүлэх буюу тэднийг байцааж нотолгоо авч болно.

2. Хэлэлцэн тохирогч нэг Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газар энэ зүйлийн I-д заасны дагуу баримт бичиг хүргүүлэх, байцааж нотолгоо авахдаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хууль тогтоомжийг зөрчих буюу хүч хэрэглэсэн ямар нэгэн арга хэмжээ авч болохгүй.

17 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх хэмжээ хязгаар

Хэлэлцэн тохирогч хоёр Тал энэхүү Гэрээнд заасан нөхцөлийн дагуу уг Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт гаргасан шүүхийн дор дурдсан шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлнэ:

а/ шүүх, эрх бүхий бусад байгууллагаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус шинжтэй иргэний хэргийн талаар гаргасан шийдвэр;

б/ шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбогдсон хэсэг;



в/ шүүхийн зардлыг төлөх тухай шүүхээс гаргасан шийдвэр;

г/ иргэний хэргийн талаар шүүхээс гаргасан эвлэрэх хэлцэл.

18 дугаар зүйл. Шийдвэрийг хүлээн зөвшөөрөхөөс болон биелүүлэхээс татгалзах

Энэхүү Гэрээний 17 дугаар зүйлд заасан шийдвэрийг мөн Гэрээний 9 дүгээр зүйлд заасан үндэслэлээр татгалзаж болохоос гадна дор дурдсан үндэслэлийн аль нэгээр хүлээн зөвшөөрөхөөс болон биелүүлэхээс татгалзаж болно:

а/ шийдвэр гаргасан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу уг шийдвэр хүчин төгөлдөр болоогүй буюу биелэх боломжгүй бол;

б/ шийдвэр гаргасан Хэлэлцэн тохирогч Талын шүүх нь даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу уг хэргийг эрхлэх эрхгүй бол;

в/ байцаан шийтгэх ажиллагаанд оролцоогүй зохигчдыг шийдвэр гаргасан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу албан ёсоор дуудаагүй буюу байцаан шийтгэх ажиллагаанд оролцох чадваргүй байсан үед нь тэдний хууль ёсны төлөөлөгч оролцоогүй бол;

г/ даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын шүүх нь тухайн зохигчдын хооронд үүссэн нэг төрлийн хэргийн талаар хүчин төгөлдөр шийдвэр гаргасан; мөн хэргийн талаар байцаан шийтгэх

10.

ажиллагаа явуулж эхэлсэн; уг хэргийн талаар гуравдахь улсад гаргасан хүчин төгөлдөр шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн бол.

19 дүгээр зүйл. Шийдвэрийг  
хүлээн зөвшөөрөх, биелүүлэх  
журам

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүх нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагын шийдвэрийг өөрийн улсын хууль тогтоомжид заасан журмын дагуу хүлээн зөвшөөрч, биелүүлнэ.

2. Даалгавар хүлээн авсан шүүх зөвхөн энэхүү Гэрээнд заасан нөхцөл бүрдсэн эсэхийг тогтооно.

20 дугаар зүйл. Шийдвэрийг хүлээн  
зөвшөөрч биелүүлэх тухай хүсэлт  
гаргах

Шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх тухай хүсэлтийг уг хэргийн талаар анхан шатны журмаар шийдвэр гаргасан эрх бүхий байгууллагад хандаж тавина. Уг эрх бүхий байгууллага хүсэлтийг даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын энэхүү Гэрээний 3 дугаар зүйлд заасан төв байгууллагад хүргүүлнэ. Хэрэв хүсэлт тавьсан этгээд даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт байнга буюу түр оршин суудаг бол хүсэлтээ уг шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх шүүхэд шууд тавьж болно.

21 дүгээр зүйл. Хүсэлтэд хавсаргах  
баримт бичиг

Шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх тухай хүсэлтэд дор дурдсан зүйлийг хавсаргана:

## II.

а/ шүүхийн шийдвэр буюу түүний баталгаатай хуулбар. Хэрэв шийдвэрт өөрт нь уг шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох тухай болон түүнийг биелүүлж болохыг тодорхой заагаагүй бол уг шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бөгөөд түүнийг биелүүлбэл зохих тухай албан ёсны баримт бичиг;

б/ байцаан шийтгэх ажиллагаанд оролцоогүй зохигчдыг албан ёсоор дуудаад ирээгүй болон тэрээр байцаан шийтгэх ажиллагаанд оролцох чадваргүй үед хууль ёсны төлөөлөгч оролцсон тухай магадлагаа.

22 дугаар зүйл. Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх явдал хүчин төгөлдөр болох

Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүхийн шийдвэр нь түүнийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын шүүх хүлээн зөвшөөрөх буюу биелүүлэхээр тогтоомогц энэ Талын шүүхийн шийдвэртэй нэгэн адил хүчин төгөлдөр байна.

### ГУРАВДУГААР ХЭСЭГ

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН  
ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ

23 дугаар зүйл. Эрх зүйн туслалцааны хэмжээ хязгаар

Хэлэлцэн тохирогч Тал бүр нөгөө Талынхаа хүсэлтээр эрүүгийн хэргийн талаархи баримт бичгийг харилцан хүргүүлэх, гардуулан өгөх, зохигчид, сэжигтэн, ялтан, гэрч, шинжээч болон байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч бусад этгээдийг мөрдөн байцаах,



12.

магадлагаа, үзлэг, шинжилгээ хийх буюу мөрдөн шалгаж нотолгоо гаргуулан авахтай холбогдсон байцаан шийтгэх бусад ажиллагаа явуулна.

24 дүгээр зүйл. Даалгавар  
биелүүлэх, биелэлтийг мэдэгдэх

Энэхүү Гэрээний 14, 15 дугаар зүйлийн заалтуудыг эрүүгийн хэргийн хувьд нэгэн адил хэрэглэнэ.

25 дугаар зүйл. Эрүүгийн хэргийн  
эрх зүйн туслалцаа үзүүлэхээс  
татгалзах

Даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч нэг Тал энэхүү Гэрээний 9 дүгээр зүйлд заасан үндэслэлээр татгалзаж болохоос гадна дор дурдсан үндэслэлийн аль нэгээр эрүүгийн хэргийн эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно:

а/ уг даалгаварт заасан үйлдэл нь даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу гэмт хэрэг биш байвал;

б/ уг даалгаварт нэр дурдсан ялтан буюу сэжигтэн нь даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын харьяат бөгөөд даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт байхгүй бол.

26 дугаар зүйл. Мөнгө, эд зүйлийг  
шилжүүлэх

I. Хэлэлцэн тохирогч нэг Тал өөрийн нутаг дэвсгэрт олдсон бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээдээс уг хэргийг үйлдэх үедээ ашигласан эд зүйл болон гэмт хэргийн замаар олж авсан мөнгө, эд зүйлийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хүсэлтээр түүнд шилжүүлэн өгнө. Харин мөнгө, эд зүйлийг шилжүүлэхдээ эдгээртэй холбоотой гуравдахь этгээдийн хууль ёсны эрх ашигт хохирол учруулж болохгүй.

13.

2.Хэрэв дээр дурдсан мөнгө, эд зүйл нь даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт эрүүгийн хэргийг шүүн тасалж дуусгахад ач холбогдолтой байвал даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал уг мөнгө, эд зүйлийг шилжүүлэн өгөх хугацааг түр хойшуулж болно.

27 дугаар зүйл.Таслан шийдвэрлэх  
тогтоолын тухай болон ял шийтгэгд-  
сэн эсэх тухай мэдэгдэх

1.Хэлэлцэн тохирогч Тал бүр өөрийн шүүхээс Хэлэлцэн тохи-  
рогч нөгөө Талын иргэний тухайд гаргасан хуулийн хүчин төгөл-  
дөр таслан шийдвэрлэх тогтоолын тухай жил тутам харилцан мө-  
дээлж байна.

2.Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт урьд нь ял  
шийтгүүлж байсан этгээд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвс-  
гэрт эрүүгийн хариуцлагад татагдаж байгаа бол түүний ял шийтгэг-  
дэж байсан тухай мэдээг Хэлэлцэн тохирогч энэ Талын хүсэлтээр  
өгнө.

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ

БУСАД ЗААЛТ

28 дугаар зүйл.Зөвлөлдөх

1.Хэлэлцэн тохирогч хоёр Тал энэхүү Гэрээг хэрэгжүүлэх яв-  
цад бэрхшээл тохиолдвол дипломат шугамаар буюу энэхүү Гэрээний  
3 дугаар зүйлд заасан төв байгууллагаар дамжуулан харилцаж шийд-  
вэрлэнэ.

2.Хэлэлцэн тохирогч хоёр Тал эрүүгийн хэргийн талаар хол-  
богдох этгээдийг шилжүүлэн өгөх, дамжуулан өнгөрүүлэх асуудлыг

оролцуулан хоёр Талын эрх зүйн туслалцаа үзүүлэх хэмжээ хязгаарыг өргөжүүлэх болон хоёр Талын эрх бүхий байгууллага эрх зүйн туслалцааны талаархи харилцаанд тус дэмжлэг үзүүлэх асуудлыг дипломат шугамаар зөвлөлдөж болно.

29 дүгээр зүйл. Хууль тогтоомжийн талаар мэдээлэл солилцох

Хэлэлцэн тохирогч Тал бүр нөгөө Талын хүсэлтээр өөрийн улсын хууль тогтоомж, түүнийг хэрэглэх асуудлаар харилцан мэдээлж, холбогдох материал солилцож байна.

30 дугаар зүйл. Иргэний гэр бүлийн байдлын болон бусад баримт бичиг хүргүүлэх

Энэхүү Гэрээг хэрэгжүүлэх зорилгоор Хэлэлцэн тохирогч нэг Талын эрх бүхий байгууллага Хэлэлцэн тохирогч нөгөө Талд шүүн таслах үйл ажиллагаа явуулахад нь шаардлагатай өөрийн Талын иргэний гэр бүлийн байдлын болон бусад баримт бичгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хүсэлтээр энэхүү Гэрээний 3 дугаар зүйлд заасан журмын дагуу хүргүүлж болно.

31 дүгээр зүйл. Эд зүйл гаргах болон мөнгө гуйвуулах

Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрээс Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт энэхүү Гэрээний дагуу эд зүйл гаргах буюу мөнгө гуйвуулахад нутаг дэвсгэрээс нь эд зүйл гаргах буюу мөнгө гуйвуулах тухайн улсын хууль тогтоомжийг баримтална.



15.

ТАВДУГААР ХЭСЭГ

ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

32 дугаар зүйл. Гэрээг соёрхон батлах,  
Гэрээ хүчин төгөлдөр болох

Энэхүү Гэрээг соёрхон батлах бөгөөд Батламж жуух бичгийг  
Бээжин хотод солилцсоноос хойш 30 хоногийн дараа уг Гэрээ хү-  
чин төгөлдөр болно.

33 дугаар зүйл. Гэрээ хүчин төгөлдөр  
байх хугацаа

Энэхүү Гэрээг хугацаагүй байгуулсан болно.

Хэлэлцэн тохирогч аль нэг Тал энэхүү Гэрээг цуцлах тухай-  
гаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талд бичгээр мэдэгдсэнээс хойш зур-  
гаан сар өнгөртөл энэхүү Гэрээ хүчин төгөлдөр байна.

Энэхүү Гэрээг 1989 оны наймдугаар сарын 31 -нд Улаан-  
баатар хотод монгол, хятад хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн  
бөгөөд эх хувиуд нь адил хүчинтэй байна.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД  
УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС



БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД  
УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС



# 蒙古人民共和国和中华人民共和国 关于民事和刑事司法协助的条约

蒙古人民共和国和中华人民共和国（以下简称“缔约双方”），在相互尊重国家主权和平等互利的基础上，为发展并加强两国在司法领域的友好合作，决定缔结本条约。

为此目的，缔约双方议定下列各条：

## 第一章 总 则

### 第一条 司法保护

一、缔约一方国民在缔约另一方境内，享有与缔约另一方国民同等的司法保护。

为此目的，缔约一方国民可以在与缔约另一方国民同等的条件下，在缔约另一方法院进行诉讼或向其他主管机关提出请求。

二、本条第一款的规定亦适用于缔约双方的法人。

## 第二条 司法协助的提供

一、缔约双方的主管机关应按照本条约的规定，相互提供民事和刑事司法协助。

二、在本条约中，“主管机关”系指法院、检察院和其他主管民事或刑事案件的机关。

## 第三条 联系途径

一、除本条约另有规定外，缔约双方的主管机关在相互请求或提供司法协助时，应通过各自的中央机关相互联系。

二、本条第一款所指的“中央机关”在蒙古人民共和国方面系指蒙古人民共和国司法仲裁部和蒙古人民共和国最高法院，在中华人民共和国方面系指中华人民共和国司法部和中华人民共和国最高人民法院。

## 第四条 请求书的内容和格式

一、请求司法协助应使用请求书。请求书应包括下列内容：



- (一) 请求机关和被请求机关的名称和地址；
- (二) 案件的名称；
- (三) 执行请求所需涉及的人的姓名、性别、国籍、出生地、出生日期、职业、住所或居所及其在诉讼中的身份，法人的名称和地址；
- (四) 必要时，当事人的代理人的姓名和地址；
- (五) 请求所涉及的案件的案情摘要；如请求刑事司法协助，还应写明该项请求所涉及的犯罪的罪名及犯罪事实；
- (六) 执行请求所需附具的其他材料；
- (七) 请求的内容。
- 二、请求书应由请求机关签署并加盖公章。

### 第五条 司法协助的费用

- 一、缔约双方提供司法协助时应相互免费。
- 二、被通知到提出请求的缔约一方境内出庭的证人或鉴定人的旅费和食宿费，由提出请求的缔约一方承担。此外，鉴定人还有权取得鉴定费。
- 被通知人有权取得的费用，应在出庭通知中注明。
- 发出通知的缔约一方的机关应根据被通知人的要求预

付费用。

## 第六条 对证人和鉴定人的保护

一、对于按照缔约一方主管机关的通知前来出庭的证人或鉴定人，不论其国籍如何，不得因其入境前所犯的罪行或者因其证词、鉴定结论而追究其刑事责任、进行审讯、逮捕、关押或采取其他强制措施。

二、证人或鉴定人在提出请求的缔约一方声明其无需继续停留之日起十五天内如能离开而仍未离开提出请求的缔约一方境内，即丧失本条第一款所给予的保护。但证人和鉴定人由于本人不能控制的原因而未离开提出请求的缔约一方境内的期间不包括在内。

三、不得强迫或威胁证人或鉴定人出庭。

## 第七条 文书的效力

一、缔约一方主管机关根据本国法律制作或证明的文书，无需认证，即可在缔约另一方境内使用。

二、缔约一方主管机关制作的官方文书在缔约另一方境内具有与缔约另一方主管机关制作的类似文书同等的效

力。

## 第八条 文字

一、司法协助请求书及其附件应用提出请求的缔约一方的文字书写，并附有缔约另一方文字的经证明无误的正式译本或英文译本。

二、缔约一方主管机关向缔约另一方提供司法协助时，使用本国文字。

三、缔约双方的中央机关使用英文进行联系。缔约双方亦可使用以蒙文、中文和英文制作的表格，并交换表格样本。

## 第九条 司法协助的拒绝

如果被请求的缔约一方认为提供司法协助有损于本国的主权、安全或公共秩序，可以拒绝提供，但应将拒绝的理由通知提出请求的缔约一方。



## 第十条 司法协助适用的法律

被请求机关应依其本国法律执行请求。在不违背本国法律的情况下，被请求机关亦可根据请求机关的请求，适用提出请求的缔约一方的诉讼程序规则。

## 第二章 民事方面司法协助

### 第十一条 定义

在本条约中，“民事司法协助”亦包括在经济、婚姻和劳动等方面的司法协助。

### 第十二条 诉讼费用的减免

关于在缔约一方境内参加诉讼活动的缔约另一方国民在与该缔约一方国民同等的条件下和范围内减免与案件审理有关的诉讼费用问题，应根据其申请，由受理该申请的缔约一方法院依其本国法规决定。

### 第十三条 送达文书和调查取证

缔约双方应根据请求相互代为送达司法文书和司法外文书，询问当事人、证人和鉴定人，进行鉴定、勘验以及其他与调查取证有关的诉讼行为。

### 第十四条 请求的执行

一、如果被请求机关无权执行请求，应将该项请求转送有权执行的主管机关，并通知请求机关。

二、被请求机关如果无法按照请求书所示的地址执行请求，应依其本国法律采取适当措施确定地址，必要时可要求请求机关提供补充情况。

三、如因无法确定地址或由于其他原因不能执行请求，被请求机关应通知请求机关，说明妨碍执行的原因，并退回请求书及其所附的全部文件。

### 第十五条 通知执行情况

一、被请求的缔约一方应将执行请求的情况通知提出请求的缔约一方，并附送达回证或所取得的证据材料。

二、送达回证应有送达机关的盖章、送达人和收件人的签名，以及送达的方式、日期和地点。如收件人拒收，应注明拒收的事由。

## 第十六条 外交或领事机关的职能

一、缔约一方可以通过本国派驻缔约另一方的外交或领事机关向在另一方境内的本国国民送达文书或调查取证。

二、缔约一方的外交或领事机关根据本条第一款的规定送达文书或调查取证时，不得违反缔约另一方的法律，亦不得采取任何强制措施。

## 第十七条 承认与执行裁决的范围

缔约双方应依照本条约规定的条件，承认与执行本条约生效后在缔约另一方境内作出的下列裁决：

（一）法院或其他主管机关对财产性或非财产性民事案件作出的裁决；

（二）法院就刑事案件中有关损害赔偿部分作出的裁决；

（三）法院对诉讼费用的裁决；



(四) 法院就民事案件作出的调解书。

### 第十八条 承认与执行的拒绝

对本条约第十七条列举的裁决，除可按本条约第九条的规定拒绝承认与执行外，有下列情形之一的，也可拒绝承认与执行：

(一) 根据作出裁决的缔约一方的法律，该裁决尚未生效或不能执行；

(二) 根据被请求的缔约一方的法律，作出裁决的缔约一方法院对该案件无管辖权；

(三) 根据作出裁决的缔约一方法律，未参加诉讼的败诉一方当事人未经合法传唤，或在没有诉讼行为能力时未能得到适当的代理；

(四) 被请求的缔约一方法院对于相同当事人之间就同一标的的争讼案件已经作出了生效裁决；或已先受理了上述案件；或已承认了在第三国对该案件所作的生效裁决。

### 第十九条 承认与执行的程序

一、缔约一方法院应根据其本国法律规定的程序承认

与执行缔约另一方主管机关的裁决。

二、被请求法院仅限于审查本条约所规定的条件是否具备。

## 第二十条 承认与执行的请求的提出

请求承认与执行裁决的请求书，应提交给对该案作出第一审裁决的主管机关，由该主管机关转交给本条约第三条规定的被请求的缔约一方的中央机关。如果提出请求的当事人在被请求的缔约一方境内有住所或居所，亦可由该当事人直接向有权承认与执行裁决的法院提出请求。

## 第二十一条 请求书应附的文件

请求承认与执行裁决的请求书应附下列文件：

（一）判决书或经证明无误的判决书副本。如果判决书本身没有明确指出裁决已经发生法律效力和可以执行，还应附有证明裁决已经发生法律效力和可以执行的正式文件；

（二）证明未出庭的败诉一方已经合法传唤，以及在其没有诉讼行为能力时可得到适当代理的证明书。

## 第二十二条 承认与执行的效力

缔约一方的裁决一经缔约另一方法院承认或决定执行，即与缔约另一方法院作出的裁决具有同等效力。

## 第三章 刑事方面司法协助

### 第二十三条 司法协助的范围

缔约双方应根据请求，相互代为送达刑事方面的文书，询问当事人、嫌疑犯、罪犯、证人、鉴定人和其他诉讼参与人，进行鉴定、检查、勘验以及其他与调查取证有关的诉讼行为。

### 第二十四条 请求的执行和通知执行情况

本条约第十四条、第十五条的规定同样适用于刑事方面。

### 第二十五条 刑事司法协助的拒绝

除本条约第九条规定的理由外，被请求的缔约一方还



可根据下列理由拒绝提供刑事司法协助：

（一）按照被请求的缔约一方法律，该项请求提及的行为不构成犯罪；或

（二）该项请求所涉及的罪犯或嫌疑犯具有被请求的缔约一方的国籍，且不在提出请求的缔约一方境内。

## 第二十六条 赃款赃物的移交

一、缔约一方应根据缔约另一方的请求，将在其境内发现的罪犯在缔约另一方境内犯罪时所获的赃款赃物移交给缔约另一方。但此项移交不得侵害与这些财物有关的第三者的合法权利。

二、如果上述赃款赃物对被请求的缔约一方境内未决刑事诉讼案件的审理是必不可少的，则被请求的缔约一方可暂缓移交。

## 第二十七条 判决及判刑情况的通报

一、缔约双方应每年相互通报各自法院对缔约另一方国民作出的已经发生法律效力的判决的情况。

二、如在缔约一方境内曾被判刑的人在缔约另一方境

内被追究刑事责任，则该缔约一方应根据缔约另一方的请求提供以前判刑的情况。

#### 第四章 其他规定

##### 第二十八条 协商

一、缔约双方在执行本条约过程中的困难，应通过外交途径或通过本条约第三条所指的中央机关联系解决。

二、缔约双方可通过外交途径就扩大双方司法协助范围包括刑事犯的引渡和过境方面的合作，以及便利双方主管机关在司法协助方面的联系问题进行协商。

##### 第二十九条 交换法律情报

缔约双方应根据请求，相互通报各自国家的法律及其实施情况，并交换有关资料。

##### 第三十条 户籍文件及其他文件的送交

为了实施本条约，缔约一方主管机关可根据缔约另一方的请求，通过本条约第三条规定的途径，将诉讼中所需

的缔约另一方国民的户籍文件及其他文件送交缔约另一方。

### 第三十一条 物品的出境和金钱的汇出

根据本条约从缔约一方境内向缔约另一方境内寄出物品或汇出金钱时，应遵守本国关于物品的出境和金钱的汇出方面的法律规定。

## 第五章 最后条款

### 第三十二条 条约的批准和生效

本条约须经批准。批准书在北京互换。本条约自互换批准书之日起第三十天开始生效。

### 第三十三条 条约的有效期

本条约自缔约任何一方书面通知缔约另一方终止之日起六个月后失效，否则，本条约永远有效。



本条约于一九八九年八月三十一日在乌兰巴托签订，一式两份，每份均用蒙文和中文写成，两种文本具有同等效力。

蒙古人民共和国  
代 表



中华人民共和国  
代 表



ЦАХИМ АШМГАЛТЫН ХУМ  
Gedegedо hereit оа Doibt Ferhiwt



